

ТАНИЛЦУУЛГА

*Цагийн хөлсний хэмжээ, олгох журам
батлах тухай Хөдөлмөр, нийгмийн
хамгааллын сайдын тушаалын төсөл
боловсруулсан тухай*

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 37 дугаар зүйлийн 37.8-д “Даатгуулагч, хүн, ажил олгогч, нийгмийн даатгалын байгууллагын хооронд гарсан саналын зөрөө, маргааныг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий Маргаан хянан шийдвэрлэх төв зөвлөл /цаашид "төв зөвлөл" гэх/-ийг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд, Маргаан хянан шийдвэрлэх салбар зөвлөл /цаашид "салбар зөвлөл" гэх/-ийг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газрын дэргэд тус тус ажиллуулна” гэж, мөн хуулийн 42 дугаар зүйлийн 42.10-т “Төв зөвлөл болон салбар зөвлөлийн дарга, гишүүн, салбар зөвлөлийн нарийн бичгийн даргад хуралд оролцсон цагийг харгалзан цагийн хөлс олгоно” гэж, мөн зүйлийн 42.11-т “Энэ хуулийн 42.10-т заасан цагийн хөлсний хэмжээ, олгох журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж тус тус заасан.

Иймд хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Цагийн хөлсний хэмжээ, олгох журам батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын төсөл болон журмын төслийг тус тус боловсруулав.

Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлд жилд дунджаар 480 гаруй өргөдөл, гомдол, хүсэлт ирдэг бөгөөд нийт өргөдөл, гомдол, хүсэлтийн 90 гаруй хувийг шийдвэрлэж ажилладаг. Нийт ирсэн өргөдөл, гомдол, хүсэлтийн 60 гаруй хувийг тэтгэврийн асуудлаар ирүүлж байгаа ба хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж, өндөр насны тэтгэвэр тогтоолгох тухай асуудал голлох хувийг эзэлж байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх гомдлын шаардлагын зөвлөл /хуучин нэрээр/ 7 удаа, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагын дэргэдэх гомдлын шаардлагын зөвлөл нийт 152 удаа тус тус хуралдсан байна.

Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн бүрэлдэхүүнд хуралдсан цагаар нь хөлс олгодог бөгөөд 2022 онд 18.7 сая төгрөгийн цагийн хөлс олгож, 2023 онд 59.4 сая төгрөг, 2024 онд 79.6 сая төгрөгийг тус тус төсөвлөсөн болно.

Энэхүү тушаалын төсөл батлагдсанаар нийгмийн даатгалын сангийн болон улсын төсвөөс нэмэлт хөрөнгө шаардагдахгүй.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ